

ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТСИЙН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Б.УНДРАЛЫН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Гүйцэтгэлийн түвшин	Эхэлсэн дууссан хугацаа
					Хүрсэн түвшин (биелэлт)	
	1	2			3	
Зорилт 1. Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах						
1	Хамтын ажиллагааны арга хэмжээг зохион байгуулсан байдал, гэрээ, хэлцэл, төсөл хөтөлбөрийн хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэл эр	-	Гадаад худалдааны статистик зэрэгцүүлэлтийн чиглэлээр хамтын ажиллагааг үнэлж, дүгнэн, цаашдын чиглэлийг тодорхойлсон байна.	БНХАУ-ын ГЕГ-тай: БНХАУ-ын Гаалийн байгууллагатай цаг үеийн болон тулгамдсан асуудлаар тайлант хугацаанд 200 орчим цахим захидал (и-мэйл болон вичат зэрэг цахим хэрэгслээр), 81 орчим албан бичиг солилцсон. Мөн БНХАУ-ын Гаалийн байгууллагатай цаг үеийн болон тулгамдсан асуудлаар 420 орчим удаа ви чатаар холбогдож, цахим захидлыг тухай бүр удирдлагад танилцуулан холбогдох газар, хэлтсийг мэдээллээр хангаж гадаад хамтын ажиллагааны хүрээнд хамтран ажилласан байна. Үүнд: “ИААН хөтөлбөрийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай МУ-ын ГЕГ болон БНХАУ-ын ГЕГ хоорондын хэлэлцээр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд хятадын талтай 5 чиглэлээр санал солилцон ажилласан. - Хоёр орны гаалийн байгууллага 5 чиглэлийн уулзалтыг хоёр улсад ээлжлэн зохион байгуулахаар ГЕГ-ын дарга Р.Отгонжаргал БНХАУ-ын ГЕГ - ын даргад санал тавьсан ба тааламжтай үедээ айлчлан ирж дээрх уулзалтуудыг зохион байгуулахаар тохиролцсон. - БНХАУ-тай хиллэдэг 5 боомтын 2023 оны статистик мэдээллийг бүрэн солилцож цаашдын чиглэлийг тодорхойлсон. Биелэлтийн хувь: 100	01.01-11.30
Зорилт 4. “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”						
2	Албан хаагчдыг гадаад болон гадаадын экспертүүдийн сургалтад хамруулсан байдал, үр дүнг тооцох	Хэрэгжилт, гүйцэтгэл эр	-	Албан хаагчдыг гадаадад болон гадаадын экспертүүдийн сургалтад хамруулах, сургалтын үр дүн гаалийн байгууллагын үйл ажиллагаанд	Гадаад хамтын ажиллагааны хүрээнд хоёр талт болон олон талт сургалт уулзалтуудад зохион байгуулагч талтай харилцан мэдээлэл солилцож, БНХАУ-ын ГЕГ, БНХАУ-ын Худалдааны Яам, НҮБ болон бусад холбогдох байгууллагуудад алба хаагчдын бүртгэлийн мэдээллийг албан тоот болон цахимаар хүргүүлж, мэдээллүүдийг тухай бүрд бэлтгэн удирдлага болон алба хаагчдад танилцуулж Broadcast хийж, сургалт, уулзалтад хамрагдсан тухай тайлан мэдээллийг дотоод сүлжээгээр нийтэд түгээн ажилласан. Үүнд:	01.01-11.30

	ажлыг зохион байгуулсан байдал			хэрэгжиж үр дүнгээ өгөх. Үүнд: Гадаад хамтын ажиллагааны хүрээнд хоёр талт болон олон талт 15 уулзалт; - Олон талт болон хоёр талт хамтын ажиллагааны хүрээнд 5 сургалт зохион байгуулах	БНХАУ-ын Худалдааны Яам болон БНХАУ ГЕГ-ын Хууль бус наймаатай тэмцэх газар, НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх газар болон бусад холбогдох байгууллагуудаас зохион байгуулсан нийт 17 удаагийн сургалтад гаалийн байгууллагаас нийт 50 гаруй албан хаагчдыг хамруулсан. Үүнээс БНХАУ-ын Худалдааны Яамнаас зохион байгуулсан сургалтад нийт 13 алба хаагчийг цахим болон биетээр хамруулсан байна. Монголын хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүтээн байгуулалтын төслийн хүрээнд БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хөххот хотноо зохион байгуулагдсан сургалтад нийт 5 алба хаагч, БНХАУ-ын ӨМӨЗО-ы Эрээн хотноо Хятад, Монгол хоёр орны нийгмийн эрүүл мэндийн хамтын ажиллагааг үргэлжлүүлэн хөгжүүлэх, боомтын тарваган тахал зэрэг халдварт өвчний хамтарсан мониторингийн ажлын уулзалтад нийт 3 алба хаагч, БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хөлөнбуйр хотын дарга Жи Юнчян тэргүүтэй төлөөлөгчдийн “Зөвшилцөл” танхимд зохион байгуулагдсан хамтарсан уулзалтад нийт 2 алба хаагч, БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хөххот хотноо зохион байгуулагдсан МУ-ын ГХЯ, БНХАУ-ын ӨМӨЗО-ы Ардын Засгийн газар хоорондын Байнгын Зөвлөлдөх ажлын хэсгийн VI уулзалтад нийт 2 алба хаагч, Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн анхдугаар хуралдаан болон Эрээн хотноо зохион байгуулагдсан Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн уулзалтад 1 алба хаагчийг тус тус хамруулсан байна. Гаалийн байгууллагын албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх, мэргэшил, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор БНХАУ-ын ГЕГ-ын Боловсрол сургалтын төвд хандан Монгол Улсын гаалийн байцаагчдыг БНХАУ-ын ГЕГ-ын харьяа Шанхайн Гаалийн Академид гаалийн хяналт шалгалт, хууль бусаар хил нэвтрүүлэхтэй тэмцэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтад хамруулахыг хүссэн тухай 01-1.3/1158, 01-1/3891 албан тоотыг тус тус хүргүүлж ГЕГ-ын 2 алба хаагч, УХШИГГ-ын 8 алба хаагч нийт 10 алба хаагчийг мэргэшил дээшлүүлэх сургалтад хамруулан ажилласан. Биелэлтийн хувь: 100	
3	Монголын гаалийн байгууллагын үйл ажиллагааг	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Монголын гаалийн байгууллагын үйл ажиллагааг гадаад орнуудад	БНХАУ-ын Гаалийн байгууллагатай цаг үеийн болон тулгамдсан асуудлаар тайлант хугацаанд 200 орчим цахим захидал (и-мэйл болон вичат зэрэг цахим хэрэгслээр), 81 орчим албан бичиг солилцсон. Мөн БНХАУ-ын Гаалийн байгууллагатай цаг үеийн болон тулгамдсан асуудлаар 420 орчим	01.01-11.30

гадаад орнуудад сурталчилах, холбоо баригчийн үүрэг гүйцэтгэх ажлыг зохион байгуулсан байдал				сурталчилж, гаалийн асуудлаар холбоо баригчийн үүрэг гүйцэтгэн ажиллана.	удаа ви чатаар холбогдож, цахим захидлыг тухай бүр удирдлагад танилцуулан холбогдох газар, хэлтсийг мэдээллээр хангасан. Үүнд гаалийн зөрчил, хамтарсан хяналт шалгалт, боомт, статистик, хорио цээр болон захиргааны чиглэлээр байнгын холбоотой ажиллаж холбоо баригчийн үүрэг гүйцэтгэсэн. БНХАУ-ын ГЕГ-тай: “ИААН хөтөлбөрийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай МУ ГЕГ болон БНХАУ-ын ГЕГ хоорондын хэлэлцээр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд 5 чиглэлээр санал солилцон ажилласан. - Монгол Улсын угаасан ноос, ноолуурын болон малын яс, өөх тос, уураг үйлдвэрлэлийн 17 ААН-үүдэд хятадын талтай хамтран энэ онд эрсдэлийн хянан магадлагаа хийсэн. “Амьтан, ургамал хилээр оруулах, гаргах үеийн хорио цээрийн техникийн хамтын ажиллагааны тухай МУ-ын ГЕГ, БНХАУ-ын ГЕГ хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг байгуулах дотоодын процесс дуусаж гарын үсэг зурхад бэлэн болгосон. Түүнчлэн холбоо барьж ажилласаны үр дүнд: - ДГБ-ын “Бүрдүүлэлтийн дараах шалгалтын чиглэлээрх үндэсний семинар”-ыг МУ-д зохион байгуулан гаалийн албан хаагч нарыг хамруулсан. - Монголын гаалийн байгууллага болон БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага болох КОЙКА-н “Эрсдэлийн удирдлагын систем болон барааг сонгон шалгах үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлэх төсөл”-д (2025-2027 он) шалгарч, төслийн судалгаа хийх баг МУ-ын ГЕГ-т 2024 оны 11 сарын 25-29-ний өдрүүдэд ажилласан бөгөөд уг уулзалтыг зохион байгуулахад хамтран ажилласан. - БНХАУ-ын TIR горимын тээвэрлэлтэд тавьж буй хяналттай холбоотойгоор Гаалийн байгууллагын автоматжуулсан CAIS-тай Олон Улсын автотээвэрчдийн холбоо (IRU)-ны TIR-EDP-г холбосон техникийн туршилтыг амжилттай холбосон. Үүнтэй холбогдуулан МУ-ын гаалийн байгууллага (IRU)-ны TIR-EDP программыг ашиглах туршилтын ажлыг Эрээний Гаалийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх саналыг Хөххотын гаалийн байгууллага бүх талаар дэмжин ажиллахаа илэрхийлж, Эрээн хотын Гаалийн Авто замын хяналтын нэгдүгээр хэлтсийн орлогч дарга Е Шуайг томилсон.	
--	--	--	--	--	--	--

					- Монгол Улсын ГЕГ, БНХАУ-ын “Нук Тек” ХК-ийн олон жилийн харилцан хамтын ажиллагааг үргэлжлүүлэн (NUSTECH COMPANY LIMITED)-ийн холбогдох газар, хороодод нийлүүлсэн рентген тоног төхөөрөмжийг угсарч суурилуулах, засвар үйлчилгээ хийх ажилчдын виз олгоход дэмжлэг хүссэн албан бичгийг Гадаадын иргэн, харьяатын газрын Виз зөвшөөрлийн газарт хүргүүлж, үүний дагуу БНХАУ-ын 4 иргэнд визний зөвшөөрөл олгогдсон. - МУ-ын ГХЯ, БНХАУ-ын ӨМӨЗО-ы Ардын Засгийн газар хоорондын Байнгын Зөвлөлдөх ажлын хэсгийн VI хуралдаан”-д ГЕГ-ын төлөөлөл 2 албан хаагчийг оролцуулсанаар протоколд нийт 24 зүйл хэлэлцэн тохиролцсоноос гаалийн асуудлаар Ханги-Мандал, Замын-Үүд-Эрээн зэрэг боомтуудаар тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, химийн урвалж, натрийн цианид, мөн газрын тосны бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх нөхцөл бүрдүүлэх чиглэлээр идэвхтэй хамтран ажиллахаар болсон бөгөөд дээрх бүтээгдэхүүнүүдийг нэвтрүүлэх бусад боомтыг тохиролцох ажлыг идэвхтэй урагшлуулахаар болов.Мөн хилийн хорио цээрийн бүсийн хязгаарлалтыг арилгаж, амьд мал гаргах нөхцлийг яаралтай шийдвэрлэхээр тохиролцсон. - МУ-ын ГЕГ-ын Зөрчилтэй тэмцэх газар, БНХАУ-ын ГЕГ-ын Зөрчилтэй тэмцэх газар болон Хөххотын Гаалийн Цагдаагийн газар 2024 онд хоёр улсын хоорондох хууль бус бараа тээвэрлэлтийг бууруулах, хил дамнасан хуурамч бараа, бүтээгдэхүүнийг илрүүлэх болон бусад чиглэлээр гаалийн хяналтын арга хэмжээг хамтран хэрэгжүүлж, мэдээлэл харилцан солилцсон. Тухайлбал гэмт хэргийн мэдээллийг харилцан солилцож хил орчмын бүс нутгийн хууль бус гэмт хэргийн байдал болон хууль зөрчин хар тамхи худалдаалсан, ховордсон зэрлэг ан амьтан, хатуу хог хаягдал, уул уурхай, ашигт малтмалын бүтээгдэхүүний экспорт, импортын мэдээллийг харилцан солилцсон. - БНХАУ-ын ГЕГ-ын Амьтан, ургамлын хорио цээрийн газартай Монголын экспортлогч компаниуд болон Хятадын импортлогч компаниудын бүртгэл, хяналтын мэдээллийг тогтмол солилцдог. Энэ хүрээнд Монголын байгалийн хадсан өвсийг БНХАУ-руу экспортлох ААН-үүд БНХАУ-ын Амьтан, ургамлын хорио цээрийн газраас компаниудын шинээр баригдсан хортон шавжтай тэмцэх ариутгах байгууламжийн видео хяналт, шалгалт хийлгэж, дүгнэлтээр зарим аж ахуйн нэгж экспортлох зөвшөөрлийг авсан. Мөн шинэ халдварт өвчин, хортон шавж, ургамлын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд Монгол Улсад ямааны годрон өвчин гарсан тухай, авч хэрэгжүүлсэн хорио цээрийн арга хэмжээ, БНХАУ-ын талаас	
--	--	--	--	--	---	--

					зөвшөөрөгдсөн бүс нутагт шүлхий, хонь, ямааны цэцэг өвчин гарсан эсэх мэдээлэл ирүүлэх хүсэлтийн дагуу мэргэжлийн байгууллагуудаас холбогдох мэдээллийг авч №02-1.2/4877 албан тоотоор хүргүүлж мэдээлэл харилцан солилцож, холбоо баригчийн үүрэг гүйцэтгэн ажилласан. Гаалийн байгууллагын албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх, мэргэшил, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор БНХАУ-ын ГЕГ-ын Боловсрол сургалтын төвд хандан МУ-ын гаалийн байцаагчдыг БНХАУ-ын ГЕГ-ын харьяа Шанхайн Гаалийн Академид гаалийн хяналт шалгалт, хууль бусаар хил нэвтрүүлэхтэй тэмцэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтад хамруулахыг хүссэн тухай албан тоотуудыг хүргүүлж гаалийн байгууллагын нийт 10 алба хаагчийг мэргэшил дээшлүүлэх сургалтад хамруулсан. Биелэлтийн хувь: 100	
4	Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гадаад бичиг баримт орчуулж, гадаад хурал, арга хэмжээнд албан ёсны орчуулга хийх ажлыг зохион байгуулсан байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гадаад бичиг баримт орчуулж, гадаад хурал, арга хэмжээнд албан ёсны орчуулга хийх ажлыг зохион байгуулж, орчуулгын талаар оновчтой тайлагнах.	БНХАУ-ын гаалийн байгууллагатай цаг үеийн болон тулгамдсан асуудлаар гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой цахим захидал болон албан гадаад бичиг баримтыг орчуулан ажилласан. Холбогдох байгууллагуудад мэдээллийг хүргүүлж, удирдлагад танилцуулан холбогдох хэлтэс, газарт хүргүүлэн ажилласан. Монгол Улсад 3 арга хэмжээ зохион байгуулагдсан. Тус арга хэмжээнүүдэд гадаад хамтын ажиллагаатай холбоотой гадаад бичиг баримтыг орчуулан ажилласан. Үүнээс үндэсний хэмжээний 3 уулзалт хоёр талт болон олон талт сургалтуудад зохион байгуулагч талтай харилцан мэдээлэл солилцож 59 албан хаагчийг хамруулсан. (Орчуулсан материал: 15 excel файл, 100 гаруй хуудас материал) Үүнээс дурдвал: Монгол Улсын угаасан ноос, ноолуур болон үйлдвэрийн зориулалтаар ашиглах мал амьтны гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдэд мал эмнэлгийн хяналт, үйлдвэрийн үйл ажиллагааны менежмент, түүхий эд бүтээгдэхүүний гарал үүсэл зэрэг асуудлаар хоёр талын Протоколын хэрэгжилтийг ханган БНХАУ-ын ГЕГ-ын эрсдэлийн үнэлгээний багийн хянан магадалгаа Монгол Улсад амжилттай зохион байгуулагдсан. БНХАУ-ын талаас Монгол Улсын угаасан ноос, ноолуурын 3 үйлдвэр, малын яс, өөх тос, уураг үйлдвэрлэж буй 4 аж ахуйн нэгж, мөн шинээр эрх хүссэн малын яс, техникийн бус тос, уураг үйлдвэрлэж буй 6 аж ахуйн нэгжид эрсдэлийн хянан магадалгаа ирүүлсэн дүгнэлтүүдийн хуудас албан орчуулгыг хийж холбогдох газарт хүргүүлсэн.	01.01-11.30

					БНХАУ-ын Худалдааны Яамны Олон улсын бизнесийн удирдах албан тушаалтнуудын хүрээлэн "Чөлөөт худалдааны бүс" сургалтын мэдээлэл, Жянсү мужийн Хяналт шалгалт, Хорио цээрийн Чанарын Судалгааны Төвөөс импорт, экспортын хүнсний аюулгүй байдлын хяналт, хамтын ажиллагаа сэдэвт сургалтын мэдээлэл, БНХАУ-ын ГЕГ-ын Хууль бус наймаатай тэмцэх газар, Нэгдсэн үндэстний байгууллагын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх газраас Зэрлэг ан амьтдыг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх сургалтын мэдээлэл, БНХАУ-ын Худалдааны Яамны "Хөгжиж буй орнуудын Хятад руу бүтээгдэхүүн экспортлох журам, хяналт шалгалт, хорио цээр" сэдэвт сургалтын мэдээлэл зэрэг сургалттайг холбоотой 40 гаруй хуудас материалыг орчуулан ажилласан. БНХАУ-ын албан ёсны сайт дээрх БНХАУ-ын Гаалийн дамжин өнгөрөх бараанд хяналт тавих ГЕГ-ын 260 дугаар тушаалаар батлагдсан журмын орчуулга хийж холбогдох газарт хүргүүлэн ажилласан. МУ сайд БСҮХ-ны дарга Б. Тулга Гашуунсухайт боомтод ажиллах арга хэмжээтэй холбогдуулан БНХАУ-ын битүү агуулахад тавигдах стандарт, шаардлагын талаар холбогдох баримт бичгийн орчуулгыг хийж хүргүүлсэн.	
					Биелэлтийн хувь: 100	
5	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Нэгжийн чиг үүргийн хүрээнд "Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хяналтшинжилгээ хийх, үр дүнг үнэлэх аргачлал"-д заасан бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангаж, тайлагнасан байна.	"Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө", "Алсын хараа 2050" хөтөлбөрийн хүрээнд тус нэгжийн үйл ажиллагаанд хамаарах тайлан мэдээ байхгүй болно.	01.01-11.30
					Биелэлтийн хувь: 100	
6	Цаг үеийн асуудлаар удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх			Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг тухай бүр ханган ажиллаж, тайлагнана.	Удирдлагаас өгсөн 12 үүрэг даалгаврыг цаг тухайд нь 100% биелүүлэн ажилласан. Үүнд: - БНХАУ-ын Монгол Улсад суугаа ЭСЯ-аас 255/2024 дугаартай албан бичгээр TGUHU9235343 дугаар бүхий дипломат ачаанд Замын-Үүдийн гааль дээр хяналт шалгалт хийхээр саатуулсан талаарх албан бичгийг удирдлагад танилцуулан шийдвэрлэсэн.	

					- БНХАУ-ын нутаг дэвсгэрээр авто замаар дамжуулан өнгөрүүлэхийг хориглосон ачаа болон дамжин өнгөрүүлэх нөхцөл шаардлагын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл хүссэн тухай №01-1.3/3159 албан тоотыг БНХАУ-ын ГЕГ-т болон тус газрын ОУХАГ-т хүргүүлсэн. Үүний хүрээнд БНХАУ-ын албан ёсны сайт дээрх БНХАУ-ын Гаалийн дамжин өнгөрөх бараанд хяналт тавих ГЕГ-ын 260 дугаар тушаалаар батлагдсан журмын албан бус орчуулгыг хийж холбогдох газарт хүргүүлэн ажилласан. - БНСУ-ын Амьтан, ургамлын хорио цээрийн газрын хүсэлттэй холбоотой асуудал: 2024 оны есдүгээр сард Сөүл дэх МУ-ын ЭСЯ-аас экспортын мал эмнэлгийн гэрчилгээ олгох эрхийг Гаалийн ерөнхий газраас бүрэн эрхийг шилжүүлсэн тул амьтан, ургамал тэдгээрээс гаргаж авсан бүтээгдэхүүнийг БНСУ-ын хилээр гаргах боломгүй талаар мэдэгдэж, МУ-ын ГЕГ яагаад мал эмнэлгийн гэрчилгээний асуудалтай байгааг мэдэхийг хүссэн тухай бичгийг удирдлагад танилцуулсан ба удирдлагын заалтын дагуу МУ-ын хуульд өөрчлөлт орсонтой холбогдуулан холбогдох дүрэм, журам, стандартууд программын шинэчлэлт хийгдэж дуусаагүй байгаатай холбогдуулан ГЕГ-аас хуучин олгогддог журмаар экспортын гэрчилгээ, импортын болон дамжуулан тээвэрлэх мэдэгдэл олгогдсон хэвээр байгаа тухай албан тоотыг /Ref:02-1.2/4698/ БНСУ-ын Амьтан, ургамлын ХЦГ-т мэдэгдэн, албан тоотыг хүргүүлсэн. БНСУ-ын Амьтан, ургамлын хорио цээрийн газраас тус албан тоотын хариуг ирүүлсэн ба зогсонги байдалд байсан монгол махан бүтээгдэхүүний хорио цээрийн ажиллагааг сэргээхэд том тус хүргэсэн тухай талархал илэрхийлсэн. - Гаалийн байгууллагын албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх, мэргэшил, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор БНХАУ-ын ГЕГ-ын Боловсрол сургалтын төвд хандан МУ-ын гаалийн байцаагчдыг БНХАУ-ын ГЕГ-ын харьяа Шанхайн Гаалийн Академид гаалийн хяналт шалгалт, хууль бусаар хил нэвтрүүлэхтэй тэмцэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтад хамруулахыг хүссэн тухай 01-1.3/1158, 01-1/3891 албан тоотоор хүргүүлж нийт 10 алба хаагчийг мэргэшил дээшлүүлэх сургалтад хамруулсан. Алба хаагчдын мэдээллийг БНХАУ-ын ГЕГ-ын Боловсрол сургалтын төв болон БНХАУ-ын ГЕГ-ын харьяа Шанхайн Гаалийн Академид тус тус хүргүүлэн ажилласан. - МУ-аас уул уурхайн экспортын эрдэс бүтээгдэхүүнийг биржээр арилжаалах болсонтой холбогдуулан гаалийн хяналтын бүс дэх нүүрс агуулах талбай, хилийн хяналтын бүсийн задгай талбайн нүүрс хадгалалтын төлбөр зэрэг БНХАУ-д импортлох үед гарч байгаа зардал, хураамж, тэдгээртэй холбоотой эрх зүйн зохицуулалт зэрэг мэдээлэл хүссэн тухай №02/2666 албан тоотыг БНХАУ-ын ӨМӨЗО-ны Боомтын Захиргааны дарга Лю Юуминд хүргүүлсэн. - БНХАУ-ын Тяньжинь боомтоос Монгол Улс руу чиглэсэн галт тэрэгний тоог 3-аас 1 болгож бууруулсан шалтгаан болон барааны мэдээллийг БНХАУ-ын боомтуудад ирэх үед нь хоёр талын гаалийн байгууллагууд
--	--	--	--	--	---

				солилцох боломжтой эсэх асуудлаар БНХАУ-ын ГЕГ-ын ОУХАГ-т хандан албан тоот №01-1.3/2390 хүргүүлсэн. Энэ хүрээнд БНХАУ-ын ОУХАГ-аас хариуг ирүүлсэн бөгөөд гаалийн байгууллагын хяналт шалгалт нь төмөр замын чингэлгийн тээвэрлэлтэд нөлөөлж буй асуудал байхгүй талаар мөн БНХАУ нь TIR конвенцын шаардлагад нийцсэн ачаа тээврийн транзит тээврийн хэлбэрийг дэмжиж байгаа хэдий ч БНХАУ-ын нутаг дэвсгэрт нэвтэрч буй гадаадын тээврийн хэрэгсэл нь БНХАУ-ын Зам, тээврийн байгууллагаас олгосон олон улсын авто замын тээвэрлэх зөвшөөрөл авах шаардлагатай учир БНХАУ-ын Зам, тээврийн холбогдох эрх бүхий байгууллагаас лавлахыг зөвлөсөн тухай албан бичгийг холбогдох газарт удирдлагын заалтын дагуу хүргүүлэн ажилласан. -“Говь” ХК нь БНХАУ-ын Rova Sourcing International компани руу ямааны богино очёсыг БНХАУ-д экспортлох бүртгэлийг хийлгэхээр №01-1.2/4375 албан тоотыг хүргүүлсэн. БНХАУ-ын ГЕГ-ын Амьтан, ургамлын хорио цээрийн газраас амьтны гаралтай бүтээгдэхүүнийг МУ-аас БНХАУ-д суугаа ЭСЯ-аар дамжуулан ААН-ийн бүртгэл үүсгүүлэх хүсэлтийг ирүүлэх гэсэн шаардлагын дагуу 02/4574 дугаар албан тоотыг боловсруулан Монгол Улсаас БНХАУ-д суугаа Элчин сайдын яаманд 02/4575 албан тоотыг хүргүүлсэн. -БНХАУ-ын ГЕГ-аас ирүүлсэн хоёр улсын хэлэлцээрийн дагуу Монгол Улсад бүртгүүлэхээр хүсэлт гаргасан БНХАУ-ын 31 аж ахуйн нэгжийн жагсаалтын мэдээллийг албан бичиг хавсралтын хамт холбогдох хэлтэст хүргүүлсэн. - Хятадын талтай “Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийг харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрийг хэрэгжүүлэх талаар хамтран ажиллах болон санамж бичиг” байгуулан ажиллахтай холбогдуулан удирдлагын заалтын дагуу холбогдох хэлтсээс саналыг авч БНХАУ-ын талд хүргүүлэн харилцан мэдээлэл солилцон ажилласан. -“Амьтан, ургамал хилээр оруулах, гаргах үеийн хорио цээрийн техникийн хамтын ажиллагааны тухай МУ-ын ГЕГ, БНХАУ-ын ГЕГ хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг дээд шатны байгууллагад албан бичгээр хүргүүлсэн, дотоодын процесс дуусаж гарын үсэг зурхад бэлэн болгосон. - МУ-аас мах, махан бүтээгдэхүүн экспортолж буй аж ахуйн нэгжүүд Эрээн автозамын боомтоор нэвтрэх үед гэрчилгээнд бичигдэж буй аж ахуйн нэгжийн нэр том эсвэл жижиг үсгээр бичигдсэн гэх шалтгаанаар олон удаа хил нэвтрүүлэхгүй саатуулж, гэрчилгээг солиулан ирэхийг шаардаж буй талаар №02-1.2/4212 албан тоотыг БНХАУ-ын ГЕГ-ын Амьтан ургамлын хорио цээрийн газарт хүргүүлсэн. Уг асуудлын талаар БНХАУ-ын ГЕГ-ын Импорт, экспортын хүнсний аюулгүй байдлын газрын нэгдүгээр хэлтсээс
--	--	--	--	---

					ирүүлсэн бичгийн албан бус орчуулгыг хийж, ХЦХ-т дотоод зурвасаар хүргүүлэн ажилласан. - "Мэргэжил сурталчлах өдөрлөг"-ийг тохиолдуулан ЕБС-ийн ахлах ангийн 27 сурагчдад гаалийн байгууллагын үйл ажиллагаа, гүйцэтгэх үүргийг танилцуулан ажиллав. Биелэлтийн хувь: 100		
--	--	--	--	--	---	--	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн дууссан хугацаа	Бүтээгдэхүүн
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)			
	1	2	3	4	5	6		
1	Гаалийн хөгжлийн чиг хандлагаас суралцах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр,	-	Гадаад хэл дээрх мэдээллийн эх сурвалжийг харьцуулан судлана.	Гаалийн хөгжлийн чиг хандлагаас суралцаж, дэлхий нийттэй хөл нийлүүлэн алхахын тулд ДГБ-ын вебсайт https://www.wcoomd.org/ болон БНХАУ-ын ГЕГ-ын албан ёсны веб хуудаст http://www.customs.gov.cn/ тогтмол зочилж, сүүлийн үеийн мэдээллийг олон улсын байгууллагуудын эх сурвалжийн мэдээ мэдээлэл, тайлан, судалгаатай харьцуулан танилцаж, Хятад, Монгол гуравдагч талын эх сурвалжуудын мэдээлэл хооронд дүн шинжилгээ хийж, тодорхой ойлгомжгүй мэдээллийг албан ёсны байгууллагуудаас тодруулга аван харилцан судалсан. Энэхүү мэдээллүүдийг өдөр тутмын үйл ажиллагаа болон орчуулгадаа байнга ашиглаж байна.	01.01-11.30		
					Биелэлтийн хувь: 100			
2	Богино хугацааны мэргэшлийн мэдлэг дээшлүүлэх сургалтад хамрагдсан байна	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Гаалийн байгууллагын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг болж ажилласан байна.	1. Гаалийн хэргийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх сургалтад хамрагдаж гаалийн хэргийн мэдлэгээ дээшлүүлэн гэрчилгээ авсан. 2. WCO-Click Gender equality and inclusion in Customs, WCO-Click Gender equality in Customs онлайн сургалтуудад цахим хэлбэрээр тайлант хугацаанд хамрагдсан. 3. Гаалийн байгууллагын мэдээллийн цагт сууж гаалийн хэргийн мэдлэгээ дээшлүүлсэн. 4. Дэлгэрийн Баярсайхан, Баярын Эрдэнэчимэг нарын 2013 онд хянан тохируулсан "Гадаад худалдаа, тээвэр, тээвэр зууч, даатгал, банк санхүү, татвар, гааль, гаалийн зуучлал, хилийн бусад хяналт, холбогдох эрх зүйн нэр томьёо" толь бичгээс 800 хятад ханзыг	01.01-11.30		

					цээжлэн баримт бичиг боловсруулахдаа гаалийн үг хэллэгийг оновчтой ашиглах чадвараа дээшлүүлсэн.		
					Биелэлтийн хувь: 100		

ТАЙЛАН ГАРГАСАН:

ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТСИЙН
ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ

.....*Ундрал*.....

/Б.УНДРАЛ/

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТСИЙН
ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ БОЛДМЯГМАР ОВОГТОЙ УНДРАЛЫН
2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ
ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар

Нэгжийн нэр: Гадаад хамтын ажиллагааны хэлтэс

1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхийг бэхжүүлэх зорилгын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.	Олон улсын гаалийн чиглэлээр хэрэглэж буй баримт бичгийг судлаж, боловсруулсан байдал	58	10	68	
2	Хамтын ажиллагааны арга хэмжээг зохион байгуулсан байдал, гэрээ хэлцэл, төсөл хөтөлбөрийн хэрэгжилт	55	10	65	
3	Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн хөтөлбөрийг олон улсын стандартын дагуу бүрэн хэрэгжүүлэх, хөтөлбөрийн хүрээнд байгуулсан; Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх	55	10	65	
4	Олон улсын түвшинд хэрэглэгдэж байгаа дэвшилтэт арга барил, технологи, техник ажиллагааг нэвтрүүлсэн байдал	58	8	66	
5	Гадаад худалдааг хөнгөвчлөх	60	10	70	

Зорилт 2. “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх” зорилтыг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.	Албан хаагчдыг уулзалт, сургалтад хамруулсан байдал, үр дүнг тооцох ажлыг зохион байгуулна.	60	10	70	
2.	Монголын гаалийн байгууллагын үйл ажиллагааг гадаад орнуудад сурталчилсан байдал	58	9	67	
3.	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	58	10	68	
4.	Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт	55	10	65	
5.	Үүрэг даалгаврын биелэлт	58	9	67	
6.	Ажлын цаг ашиглалт	60	10	70	
7.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	59	10	69	
Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт					
1.	Цаг үеийн асуудлаар удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх	58	10	68	
2.	Үүрэг даалгавар (12 арга хэмжээ)	58	10	68	
Дундаж оноо: 67,5					

2. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийг хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Онлайн гаалийн академийн сургалтад хамрагдах, гаалийн холбогдолтой үндэсний сургалт семинарт хамрагдах	95	13	
2.	Дэлгэрийн Баярсайхан, Баярын Эрдэнэчимэг нарын 2013 онд хянан тохируулсан "Гадаад худалдаа, тээвэр, тээвэр зууч, даатгал, банк санхүү, татвар, гааль, гаалийн зуучлал, хилийн бусад хяналт, холбогдох эрх зүйн Хятад, Англи, Орос хэлний нэр томъёо"-оос 800 хятад ханзыг цээжлэн баримт бичиг боловсруулахдаа гаалийн үг	95	13	

хэллэгийг оновчтой ашиглах чадвараа дээшлүүлэх		
Дундаж оноо:		13

3. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (НЭГЖИЙН ДАРГЫН ҮНЭЛГЭЭ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7	
2.	Асуудал шийдвэрлэх	6	
3.	Хариуцлагатай байдал	7	
4.	Дүн шинжилгээ хийх	6	
5.	Ажлын цаг ашиглалт	7	
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6.	Мэргэжлийн ур чадвар 1. Хууль эрх, зүй	7	
7.	Мэргэжлийн ур чадвар 2. Хятад хэл	6	
Дундаж оноо:		6,5	

4. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (ХАМТ ОЛНЫ ҮНЭЛГЭЭ)

Д/д	Хандлага, ёс зүй, ур чадвар	Хамт олны үнэлгээ (0-8)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	8
2.	Багаар ажиллах	7
3.	Харилцаа	7
Дундаж оноо:		7,3

5. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ


Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно)	67,5
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	13
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	6,5
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	7,3

5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	
Нийт оноо =94,4		

Үнэлгээ өгсөн:

ГХАХ-ийн дарга
(албан тушаал)

Нэгжийн дарга


.....
(гарын үсэг)

/Ө. Цолмон/
(албан хаагчийн нэр)

..... (огноо)

**Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:**

ГХАХ-ийн ГУБ
(албан тушаал)


.....
(гарын үсэг)


/Б.Ундрал/
(албан хаагчийн нэр)

..... (огноо)


Үнэлгээг хянасан :

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

Дэд даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч
(албан тушаал)


.....
(гарын үсэг)

/Г. Энхтайван/



..... (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

ХНХ-ийн ГУАБ
(албан тушаал)



.....
(гарын үсэг)

/Ө. Тэгшээ /


..... (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан:

Гаалийн ерөнхий газрын дарга
(албан тушаал)



Төсвийн шууд захирагч

.....
(гарын үсэг)

/Р. Отгонжаргал/

..... (огноо)